

ТАНИЛЦУУЛГА

2017-1-26

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 2 дугаар 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж гэж байна. Үүнтэй холбоотойгоор уг хуульд заасан журмуудыг боловсруулан батлуулах шаардлагатай болсон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д “Энэ хуульд заасны дагуу хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг хууль зүй, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу тушаалын төсөл болон “Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ын төслийг боловсрууллаа.

Журмын төсөлд магадлан итгэмжлэх үйл ажиллагааны удирдлага нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, цагдаа, хүүхдийн байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий магадлан итгэмжлэх орон тооны бус комисс /цаашид “комисс” гэх/ байхаар, комиссын бүрэлдхүүнийг хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгалаа. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний ихэнх нь нийгмийн хамгааллын чиглэлээр байх бөгөөд мөн үйлчилгээний чанарын стандартыг тогтоох, зардлын тооцоог хийх зэрэг үндэслэлээр магадлан итгэмжлэх байгууллага нь нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх нь зохимжтой гэж үзсэн болно.

Мөн энэхүү журмаар магадлан итгэмжлэлийн үе шат, магадлан итгэмжлэх хүсэлт гаргах, магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэлийн батламж олгох, магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой маргаан шийдвэрлэхтэй холбогдсон харилцаануудыг зохицуулсан.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ